

**ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАЛТАД
ХИЙСЭН ДОТООД АУДИТЫН ДҮН, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Аудитын зорилго: Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулсан эсэхэд аудит хийж дүгнэх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг ТЕЗ-д хүргүүлэн төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулах.

Аудитын цар хүрээ:

-Шилэн дансны тухай хууль

-Төсвийн хууль

-Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор батлагдсан “шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”

-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 01 сарын 31-ны 16 тоот тогтоол зэрэг эрхийн актуудыг үндэслэн Шилэн дансны Төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, бусад гэсэн цэсний мэдээллүүд

Аудитад хамаарах хугацаа: 2017 оны 01 сарын 31-ны өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 01-ныг хүртэл.

Аудитад хамаарах нэгжүүд: Нийт 261 байгууллага

- Шилэн дансны тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.1-д заасан төрийн болон төрийн өмчит хуулийн этгээд гэдэгт аймгийн болон аймгийн салбар төсвийн ерөнхийлэн захирагч 18, аймгийн төсвийн ерөнхийлэн захирагчид шууд харьяалагддаг 11 байгууллага, салбар төсвийн ерөнхийлэн захирагчдын харъяа байгууллага 161.

-мөн хуулийн 3.1.2-д заасан төрийн өмчит үйлдвэрийн газар буюу ОНӨААТҮГазар 12.

-мөн хуулийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч гэдэгт 59 байгууллага.

**ХОЁР. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН,
ЗӨРЧИЛ ДУТАГДАЛ**

А. Шилэн дансанд мэдээлэл байршуулалт:

Аудит хийхэд 2017 оны эхний гурван улирлын байдлаар Сэлэнгэ аймгийн аймаг, сумдын төсвийн ерөнхийлэн захирагч 18 нэгжийн мэдээлэл байршуулалт 82,9%, аймгийн төсвийн ерөнхийлэн захирагчын харъяа 11 байгууллагын мэдээлэл байршуулалт 94%, төсвийн 161 байгууллагын мэдээлэл байршуулалт 93,3%, Төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэгч сургууль, өрхийн эрүүл мэндийн төв 13 байгууллагын мэдээлэл байршуулалт 61%, ОНӨААТҮГазар 12 аж ахуйн нэгжийн мэдээлэл байршуулалт 69,6%, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг 44 нэгжийн мэдээлэл байршуулалт 0%-тай, 2 холбоо, хорооны мэдээлэл байршуулалт 0%-тай, нийт 261 байгууллага 79,2%-тай мэдээлэл байршуулсан байна.

2.1. Шилэн дансны тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.1-д заасан төрийн болон төрийн өмчит хуулийн этгээд гэдэгт аймгийн болон аймгийн салбар төсвийн ерөнхийлэн захирагч 18 байгууллага

Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлэн захирагч, 17 сумын төсвийн ерөнхийлэн захирагч нарын шилэн дансанд мэдээлэл байршуулалтад аудит хийхэд мэдээлэл байршуулалт 82.9 хувьтай, Орхонтуул, Орхон сумын мэдээлэл байршуулалт бүрэн бус байна. Үүнд:

-Орхонтуул сум Засаг дарга П.Батбаатар, нягтлан бодогч Н.Цэндмаа нар 105 мэдээлэл байршуулахаас 74 мэдээлэл байршуулсан 26 мэдээллийг байршуулаагүй

-Орхон сум Засаг дарга Г.Бат-Орхон, нягтлан бодогч Т.Хишигжаргал 105 мэдээлэл байршуулахаас 63 мэдээлэл байршуулсан 37 мэдээллийг байршуулаагүй, санхүүгийн албаны дарга өөрчлөгдсөн байхад нэрийг хэрэглэгчийн нэрийг өөрчлөөгүй байдалтай.

Аудит хийхэд ТЕЗахирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл гэсэн мэдээллийг бүрэн байршуулдаггүй байдал нийтлэг илэрч байна.

2.2. Шилэн дансны тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.1-д заасан аймгийн төсвийн ерөнхийлэн захирагчид шууд харъяалагддаг 11 байгууллага

Сэлэнгэ аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчын харъяа нийт 11 байгууллагын шилэн дансанд мэдээлэл байршуулалт 94,0-тай байна. Эдгээр байгууллагууд нь төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг дутуу мэдээлсэн байдал илэрлээ.

2.3. Шилэн дансны тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.1-д заасан салбар төсвийн ерөнхийлэн захирагчдын харъяа байгууллага 161.

Төсвийн байгууллагуудын мэдээлэл байршуулалт дунджаар 93,3%-тай байна. Эдгээр байгууллагаас

-Түнхэл тосгон Хүүхдийн цэцэрлэг: Дарга Т.Лхагважав, нягтлан бодогч Д.Ариунжаргал 108 мэдээлэл 99 мэдээлэл байршуулаагүй,

-Түнхэл тосгон Хүн эмнэлэг: Дарга П.Отгонжаргал, нягтлан бодогч Д.Ариунжаргал 108 мэдээлэл байршуулахаас 100 мэдээлэл байршуулаагүй,

-Мандал сум Хөгжимт чуулга: Дарга Б.Дэнсмаа, нягтлан бодогч Н.Тунгалаг нар 108 мэдээлэл байршуулахаас 29 мэдээлэл байршуулаагүй байсныг аудит хийх явцад утсаар шаардаж нөхөн байршуулсан боловч хугацаа хоцорсон хэсэгт хамаарч байна.

Аудит хийхэд төсвийн байгууллагууд нь бүтэн жилээр байршуулах мэдээллүүд болох дараа жилийн төсвийн төсөл, жилийн батлагдсан төсөв, төсвийн талаар мэдээлдэггүй, мэдээлсэн хэсгийг шалгахад дараа жилийн төсөв, байгууллагын жилийн төсөв зэрэг мэдээллийг байршуулахгүй **байхгүй** гэсэн үг бичсэн байгаа нь мэдээллийнхээ утгыг ойлгодоггүй, мэдээлэлд анхаарахгүй байгааг харуулж байна.

2.4. Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 59 байгууллага.

Сэлэнгэ аймагт төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэгч 59 байгууллагаас хувийн сургууль цэцэрлэг 6, өрхийн эрүүл мэндийн төв 7 нийт 13 байгууллагын мэдээлэл байршуулалт 61,0%-тай. 44 эмнэлэг, албан журмын даатгагчдын холбоо, ахмадын хороо зэрэг 46 нэгж 2017 онд улирал тутам буюу 3 удаа мэдээлэх мэдээллийг байршуулаагүй.

Аудитын дүнд үндэслэн мал эмнэлгийн байгууллагуудтай холбоо барьж мэдээллээ байршуул гэсэн үүргийг өгөөд байна.

2.5. Шилэн дансны тухай хуулийн 3.1.2-д заасан ОНӨААТҮГазар

Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар аж ахуйн нэгж 12 байснаас Цагааннуур сумын тохижилт үйлчилгээ татан буугдсан, санхүүгийн хяналт шалгалтаар Мандал сумын Мандал хишиг хайрхан ОНӨААТҮГазар шилэн дансанд бүртгэлгүй байсныг илрүүлэн албан шаардлага хүргүүлснээр шилэн дансанд нэмж бүртгэн, 12 аж ахуйн нэгж бүртгэлтэй болсон.

ОНӨААТҮГазруудын мэдээлэл байршуулалтыг судалхад тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний талаарх мэдээлэлийг байршуулахгүй, зорилто төвшний талаарх мэдээллийг бүрэн байршуулдаггүй байдал нийтлэг дутагдал илэрч байна.

Үржлийн цөм сүргийн аж ахуй, Тариалан эрхлэлтийг дэмжих туслалцааны төв нь мэдээлэл огт байршуулахгүйгээс мэдээлэл байршуулалтын дүнд шууд нөлөөлж байна. Энэ 2 аж ахуйн нэгжийн асуудлыг шийдвэрлэх тухай албан тоот, зөвлөмжийг 2016 онд аймгийн Засаг даргад, тухайн аж ахуйн нэгжийн удирдлагуудад хүргүүлсэн боловч зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, мэдээлэл байршуулахгүй байдал 2017 онд ч үргэлжилсэн байдалтай.

Б. Тайлан илгээлт

Байгууллагын админ буюу байгууллагын дарга ерөнхий менежерүүд улирал бүр тайланг илгээдэггүй нь шилэн дансны мэдээлэл дутуу, хуулийн хэрэгжилт бүрэн хангагдаж чадахгүй байдалд хүргэж байна.

Тайлан илгээлтэд хийсэн аудитаар 202 байгууллага нэгж тайлан илгээхээс 2017 оны 9-р сард Сангийн Яамнаас ирүүлсэн мэдээллээр 14%-тай байсан бол байгууллагын удирдлагуудад хэлж зөвлөх, сургалт зохион байгуулах, Санхүү төрийн сантай хамтран ажилласны үр дүнд 109 байгууллага буюу 53% нь тайлан илгээгээд байна.

Дараах нэр бүхий 93 байгууллагын дарга, эрхлэгч, захиралууд 3-р улирлын тайланг илгээгээгүй байна. Үүнд:

№	Сум, тосгоны нэр	Байгууллагын нэр	Дарга	Нягтлан бодогч	Тайлбар
1	Алтанбулаг сум	11 жилийн сургууль	Б.Эрдэнэ-Очир	Х.Алтанхүү	
2		Хүүхдийн цэцэрлэг	Д.Болормаа	Н.Эрдэнэцэцэг	
3		Дамбо 2-р цэцэрлэг	Ж.Мөнхтуяа	Х.Алтанхүү	
4		Хүн эмнэлэг	Ц.Эрдэнэтуяа	Н.Эрдэнэцэцэг	
5		Соёлын төв	Б.Ариунзаяа	Х.Алтанхүү	
6		ИТХурал	Н.Ариунжаргал	Н.Эрдэнэцэцэг	
7		ЗДТГ	Ү.Янжиндулам	Н.Эрдэнэцэцэг	
8	Баруунбүрэн сум	Хүн эмнэлэг	Г.Бүдрагчаа	Н.Эрдэнэтуяа	
9		Соёлын төв	З.Задгай	Г.Алтанцэцэг	
10	Баянгол сум	11 жилийн сургууль	Д.Сарангэрэл	Д.Лхагвасүрэн	
11		цэцэрлэг	Ц.Орхонцэцэг	Д.Лхагвасүрэн	
12		Хүн эмнэлэг	н.Баярмаа	С.Саранцэцэг	
13		Спорт цогцолбор	Г.Ганхөлөг	Д.Лхагвасүрэн	
14		Соёлын төв	Б.Ууганжаргал	Д.Лхагвасүрэн	
15		ИТХурал	н.Батжаргал	Г.Итгэл	
16		ЗДТГ	С.Эрдэнэбаатар	С.Саранцэцэг	
17	Ерөө сум	СД ойн анги	С.Бат-Амгалан	О.Гантөгс	
18		11 жилийн сургууль	Л.Дариймаа	Р.Дариймаа	
19		Хүүхдийн цэцэрлэг	Н.Лхагвасүрэн	Р.Дариймаа	
20		Сумын эмнэлэг	Ж.Бямбажаргал	О.Гантөгс	
21		Спорт цогцолбор	Ф.Болормаа	Р.Дариймаа	
22		Соёлын төв	Ф.Болормаа	Р.Дариймаа	
23		ИТХурал	Д.Хэрлэн	Д.Золзаяа	
24		ЗДТГазар	Х.Дэлгэрмаа	Д.Золзаяа	
25	Жавхлант сум	Хүн эмнэлэг	А. Шинэ-од	А. Оюунтөгс	
26		ИТХурал	Д. Баярсайхан	А. Оюунтөгс	
27		ЗДТГ	Г. Бямбадалай	А. Оюунтөгс	
28	Зүүнбүрэн сум	11 жилийн сургууль	Б. Удрамаа	П. Оюунцэцэг	
29		цэцэрлэг	Б. Болорцэцэг	П. Оюунцэцэг	
30		хүн эмнэлэг	Ц. Алтанцэцэг	Н. Хувьзаяа	

Санхүүгийн хяналт, аудитын алба

31		соёлын төв	Д. Лхамгарьд	Ж. Өнөрмаа	
32		ИТХурал	Л. Сэрдаваа	Н. Хувьзаяа	
33		ЗДТГазар	Д. Гантулга	Н. Хувьзаяа	
34	Мандал сум	Номын сан	А.Оюунсүрэн	Н.Тунгалаг	
35		Спорт сургалт цогцолбор	Г.Баатарсүрэн	Э.Золзаяа	
36		Хөгжимт чуулга	Б.Дэнсмаа	Н.Тунгалаг	
37		Хот тохижуулах газар	Н.Баасанхүү	Н.Тунгалаг	
38		Мишээл цэцэрлэг	Л.Гантөмөр	Н.Тунгалаг	
39		Мандалхишиг хайрхан ОНӨААТҮГ	Б.Бат-Үүл	П.Одончимэг	
40		4-р сургууль	Э.Бямбасайхан	Б.Ариунаа	
41	Орхон сум	ИТХурал	Х.Мөнхзул	Г.Дөлгөөн	
42	Орхонтуул сум	11 жилийн сургууль	Д.Долгормаа	О.Наранбат	
43		9 жилийн сургууль	Н.Бүрэнцогт	О.Наранбат	
44		цэцэрлэг	З.Энхцолмон	П.Соль	Нэр солих
45		Хүн эмнэлэг	Б.Эрдэнэцэцэг	П.Соль	Нэр солих
46		Соёлын төв	М.Цогбаяр	Б.Сарнай	
47		ИТХурал	Ш.Өнөрбаяр	Б.Сарнай	
48	Сант сум	ЗДТГазар	Л.Идэр	Ц.Жавзанорлом	
49		цэцэрлэг	Л.Хүрэлмаа	Ц.Жавзанорлом	
50		Хүн эмнэлэг	А.Ганзориг	Г.Ууганцэцэг	
51		Соёлын төв	Д.Баярсүрэн	Ц.Жавзанорлом	
52		ИТХурал	С.Шижирибаатар	Г.Ууганцэцэг	
53		ЗДТГазар	А.Одхүү	Г.Ууганцэцэг	
54	Сайхан сум	11 жилийн сургууль	С.Ичинхорлоо	Н.Баяртогтох	
55		11-р хүүхдийн цэцэрлэг	Т.Уранчимэг	Д.Сарангэрэл	
56		БТ спортын газар	Ц.Гиймаа	Ч.Цэндмаа	
57		Соёлын ордон	Г.Гэрэлмаа	Э.Батзаяа	
58		ИТХурал	Д.Цэдэв	Г.Ариунаа	
59		ЗДТГазар	Б.Мөнхцэцэг	Г.Ариунаа	
60		Хот тохижуулах газар	Б.Ганбаатар	Э.Бямбасүрэн	
61	Сүхбаатар сум	4-р сургууль	Н.Энхтөр	С.Наранцэцэг	
62		6-р сургууль	Н.Баярсайхан	Б.Давааням	Нэр солих
63		7-р цэцэрлэг	Г.Төгссайхан	Б.Давааням	
64		Сүхбаатар ИТХурал	Ж.Ширчмаа	Д.Чулуунцэцэг	Нэр солих
65		ЗДТГазар	Э.Нандинэрдэнэ	Д.Чулуунцэцэг	
66		Тохжилт ҮГ	Б.Мөнхбаяр	Д.Чулуунцэцэг	Нэр солих
67	Хушаат сум	11 жилийн сургууль	Л. Оюун	М. Мөнхжаргал	
68		Цэцэрлэг	Ц. Алимцэцэг	М. Мөнхжаргал	
69		Хүн эмнэлэг	Ц. Батзаа	Р. Отгонжаргал	
70		Соёлын төв	Б. Хүсэлт	М. Мөнхжаргал	
71		ИТХурал	Н. Захирахбаатар	Ч. Мөнхзаяа	Нэр солих
72		ЗДТГазар	Н. Захирахбаатар	Ч. Мөнхзаяа	
73	Хүдэр сум	11 жилийн сургууль	Г.Цэрэндамба	З.Шинэхүү	
74		Цэцэрлэг	Д.Баярдэлгэр	З.Шинэхүү	
75		Хүн эмнэлэг	Г.Нармандах	Д.Нарангэрэл	
76		Соёлын төв	Ч.Алтанцэцэг	З.Шинэхүү	
77		ИТХурал	Р.Цогбадрах	Г.Ганцэцэг	Нэр солих
78			ЗДТГазар	Ц.Гэрэлцогт	Б.Уранчимэг

79		Ойн анги ОНӨААТҮГазар	Г.Тайванбаатар	Ш.Уранчимэг	
80	Цагааннуур сум	Спорт цогцолбор	С.Атарцэцэг	С.Атарцэцэг	Нэр солих
81	Шаамар сум	11 жилийн сургууль	Д.Ганцэцэг	Д.Алтанчимэг	
82		Хүн эмнэлэг	Б.Отгончимэг	Э.Алтанхуяг	
83		Соёлын төв	М.Жамбал	Д.Алтанчимэг	
84		ИТХурал	Ш.Цогтбаатар	Э.Алтанхуяг	
85		ЗДТГ	М.Ганболд	Э.Алтанхуяг	
86	Хэрх тосгон	Хүн эмнэлэг	Н.Эрдэнэцэцэг	М.Соёл-Эрдэнэ	
87	Номгон тосгон	Хүн эмнэлэг	Н.Өлзиймаа	Д.Одгэрэл	
88	Бугант тосгон	Хүн эмнэлэг	Г.Сахъяабазар	П.Батмөнх	
89		Захирагчын алба	Д.Эрдэнэбулган	Б.Жавхланзаяа	
90	Дулаанхаан тосгон	12 жилийн сургууль	Т.Лена	Г.Алтанзул	
91		Хүүхдийн цэцэрлэг	Х.Өлзийсайхан	Г.Алтанзул	
92		Хүн эмнэлэг	Г.Алтанцэцэг	М.Амарсайхан	
93		Соёлын төв	Т.Гантуяа	Г.Алтанзул	

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Санхүүгийн хяналт, аудитын албанаас Сэлэнгэ аймгийн болон 17 сумын /салбар/ төсвийн ерөнхийлэн захирагч, төсвийн ерөнхийлэн захирагчид шууд харъяалагддаг 11 байгууллага, 161 төсвийн байгууллага, 12 ОНӨААТҮГазар, 57 төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэгч нэгж, 2 мэргэжлийн холбоо нийт 261 байгууллага, аж ахуйн нэгжийн шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулалтад 2017 оны эхний 3-н улирлын байдлаар аудит хийхэд аймгийн дундаж мэдээлэл байршуулалт 79,2%-тай, тайлан илгээлт 53%-тай байлаа.

Шилэн дансны мэдээлэл байршуулалтад хийсэн аудитаар байршуулж буй мэдээллүүдээс дараах мэдээллүүдийг байршуулахгүй, дутуу хагас байршуулах, мэдээллийн утгаа ойлгож тайлагнахгүй байдал илэрч байна. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн

6.1.1.-д заасан тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор,

6.1.2-т заасан хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;

6.3.6-д заасан хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл,

6.4.2-т заасан тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт

6.4.6-д заасан худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн,

6.4.8-д заасан бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тогтмол мэдээлэх гэсний дагуу хөрөнгө мөнгөтэй холбоотой байгууллагын даргын тушаал шийдвэр.

Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч, мэргэжилтнүүдэд 261 байгууллагыг хуваарилан өгсний дагуу хийсэн аудитын дүнд тулгуурлан мэдээлэл дутуу байршуулсан байгууллагуудын удирдлагуудтай холбоо барьж 3 хоногийн хугацаанд нөхөн байршуулах ажил зохион байгуулах үүрэг өгч ажиллаа. Үүний үр дүнд Түнхэл тосгоны Хүн эмнэлэг, цэцэрлэг зэрэг байгууллагууд мэдээллээ нөхөн байршуулсан, салбар төсвийн ерөнхийлэн захирагч 4 сумын мэдээлэл байршуулах ажилтны нэрийг өөрчилсөн, 18 төсөвт байгууллага нэмж мэдээлэл байршуулсан байдалтай байна.

Санхүүгийн хяналт аудитын албанаас шилэн дансны хууль, хэрэгжүүлэх аргачлалын талаар 2017 онд 62 байгууллагад сургалт зохион байгуулж, хяналт шалгалт, дотоод аудит хийхдээ зөвлөмж өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан, 6 байгууллагын дарга, нягтлан бодогч нарт хугацаатай албан шаардлага хүргүүлж ажилласны үр дүнд мэдээлэл байршуулалт, мэдээллийн чанарт ахиц өөрчлөлт гараад байгаа боловч байгууллагын удирдлагаас мэдээний чанартаа анхаардаггүй, тайлангаа шалгаж илгээдэггүй, сургалтад хамрагдсан боловч өөрчлөлт гаргахгүй байх хандлага байсаар байна.

ДӨРӨВ. ХОЙШИД АНХААРАХ АСУУДЛУУД

2017 оны 4-р улиралд шилэн дансны мэдээлэл байршуулалт, тайлан илгээлтийг 100%-д хүргэхийн тулд дараах ажлуудыг хийх шаардлага тулгараад байгааг аймаг, сумдын төсвийн ерөнхийлэн захирагч нар анхаарах хэрэгтэй. Үүнд:

1. Монгол Улсын Шилэн дансны тухай хууль, Төсвийн хууль, Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор батлагдсан “шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, Сэлэнгэ аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 01 сарын 31-ны 16 тоот тогтоол зэрэг эрхийн актуудыг хэрэгжүүлж ажиллах.
2. Шилэн дансанд байршуулах мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хугацаанд мэдээлж, 6 дугаар зүйлд зааснаар илэрхийлж байх, шилэн дансанд мэдээлэл байршуулах ажилтанг томилох тушаал захирамж гаргах.
3. Сэлэнгэ аймгийн нийгэм эдийн засгийг 2016-2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд орсон шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах гэсэн заалтыг хэрэгжүүлэх ажиллах

4. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагууд хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний талаар тухай бүр мэдээлэх.
5. Мэдээлэл байршуулах, тайлан илгээх хугацааг баримталж ажиллах.
6. Сумдынхаа байгууллагын тайлан илгээгээгүй дарга, эрхлэгч нарыг хамруулан шилэн дансны хууль, журмын талаар сургалт зохион байгуулах, Санхүүгийн хяналт аудитын албанаас сургалт, зөвлөгөө авах арга хэмжээ авч ажиллах.
7. Байгууллагынхаа шилэн дансны мэдээлэл байршуулалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах хүсэлтэй бол Санхүүгийн хяналт аудитын албанд хандах.

/Аудитын дүгнэлт, зөвлөмжийг Сэлэнгэ аймгийн албан ёсны сайтад мэдээлнэ/

АУДИТЫН ДҮНГ ХЯНАЖ, НЭГТГЭСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА, САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Б.ДАРИХЖАВ